



МОНГОЛЫН ГУРВАН БУУНЫ БОЛОН ТӨМӨР БУУДЛАГЫН ХОЛБОО

STEEL CHALLENGE

ЦОМЫН ТЭМЦЭЭН 2-Р ШАТНЫ УДИРДАМЖ

НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ХЭЗЭЭ:

2025 оны 8 сарын 30-ны өдрийн Бямба гарагийн 09:00-17:00 хооронд.
Ханан Ар буудлагын клубийн талбайд. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 14-р хороо.

ХЭН ОРОЛЦОЖ БОЛОХ ВЭ?

Нээлттэй тэмцээн.

- Буудлагын холбоодын тамирчид. (хүчинтэй үнэмлэхтэй)
- Албадын тамирчид

ДАСГАЛЫН ТОО: 8

СУМНЫ ТОО: 195 (Ган зүрхэвчтэй болон шатаагч гэрэлтэгч сум ашиглахыг хориглоно)

ХОЁР. БУУДЛАГЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

Төрөл 1. Гар буу

▪ Ангилал:

OPEN - Гар буу. Опен. Хамгийн бага калибр 9мм. Электрон/оптик харааны хэрэгсэлтэй. Магазины урт 171.25 мм-с ихгүй.

LIMITED –Гар буу. Лимитед. Хамгийн бага калибр 9мм. Электрон/оптик харааны хэрэгсэлгүй. Магазины урт 171.25 мм-с ихгүй.

RFPI (Rimfire Pistol Irons) – Гар буу. 22ЛР сумтай ил хараатай.

Төрөл 2. ПиСиСи

▪ Ангилал:

РССО – Карабин. Писиси опен. Хамгийн бага калибр 9мм. Электрон/оптик харааны хэрэгсэлтэй.

Эмэгтэй ангилал, багийн дүн гарна.

ГУРАВ. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

1. Бүртгэл: <https://www.asianshooting.academy/competition/schedule>

2. Бүртгэл дуусах хугацаа: 2025/08/29 22:00

3. Тэмцээний хураамж: 60,000 төгрөг (Төлбөр бүртгэл хийгдэх үед онлайнаар хийгдэх боломжтой)

**Тамирчин 2 төрөлд давхар оролцож болно. Тус бүр төлбөртэй.*

ГУРАВ. ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛ

Медаль, батламж, ивээн тэтгэгчийн шагнал.

Тэмцээний ерөнхий зохион байгуулагч: П.Эрдэнэбилэг

Тэмцээний ерөнхий шүүгч: М.Баярсайхан

ДӨРӨВ. ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

2025 оны 8 дугаар сарын 30	
09:00-10:00	Тэмцээний бүртгэл баталгаажуулах. Тэмцээний нээлт, танилцуулга. Буудлага эхлэх.
13:00-14:00	Завсарлага
14:00-16:00	Буудлага дуусгах. Тэмцээний хаалт

ТАВ. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ, ШААРДЛАГА

- Аливаа сум хэрэгслийг Шүүгч аюултай гэж үзвэл тэмцээнд ашиглахыг зөвшөөрөхгүй.
- Гар бууг бүсний дотор болон суга, цээжинд зүүхийг хориглоно. Иргэний болон спортын буудагч гар бууг зөвхөн ташаанд зүүнэ. Гар буу гэрт байх үед гохны хэсэг бүрэн далдлагдсан байна. Гар бууны гэр бүс нь өмдний 3-с доошгүй гогцоонд найдвартай бэхлэгдсэн байна. Гэрт хийсэн гар бууны гол төмрийн чиглэл буудагчийн хөлөөс 1м-с ихгүй байна.
- Тэмцээнд оролцохдоо буудагчид АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ-ийг чанд сахина.

Аюулгүй ажиллагааны дүрэм: - Аливаа галт зэвсэгтэй үргэлж цэнэгтэй гэж болгоомжлон харьцана. - Галт зэвсэг буудлага үйлдэхээс бусад тохиолдолд үргэлж цэнэггүй байна. - Буудлага үйлдэхээс бусад үед гох дээр хуруу тавихгүй. - Зэвсгийн хошуу байнга аюулгүй зүгт, буудлагын үед бай руу чиглүүлнэ. - Буудлага үйлдэхдээ бай болон эргэн тойрноо байнга хянаж эрсдэлээс сэргийлнэ.
--

- Буудлагын талбайд байгаа бүх буудагчийн буу магазин угсраагүй, цэнэггүй бууны гэрт болон бууны тавиурт эсвэл зориулалтын цүнх, хайрцагт хийгдсэн байна.
- Буудлагын талбайд байгаа хүн бүр хамгаалалтын нүдний шил, чихэвчийг байнга зүүнэ.
- Шүүгчийн зөвшөөрөлгүйгээр бууг гэрнээс гаргах, тавиураас авах, магазин угсрахыг хориглоно.
- Талбайн аль ч хэсэгт бууг газар унагасан бол шүүгчээр авхуулж, аюулгүй ажиллагааг хангана.
- Шүүгч болон дасгал гүйцэтгэх буудагчаас бусад этгээд галын шугам нэвтэрч орохыг хориглоно. Шүүгчийн зөвшөөрлөөр аюулгүй ажиллагааны нөхцөлийг ханган зураг авах, бичлэг хийх, бай хянах зорилгоор нэгээс илүүгүй хүн шүүгчийн ард галын шугам нэвтэрч болно.

9. Буутай харьцах бүх үйлдэл галын шугам дээр бол зөвхөн шүүгчийн командаар, АЮУЛГҮЙН БҮС дээр бол зөвхөн дор дурдсан нөхцөлөөр хийгдэнэ.

АЮУЛГҮЙН БҮС гэж буу, магазиныг задалж угсрах, цэвэрлэх, тослох, засвар үйлчилгээ хийх эсвэл аюулгүй зүгт хуурай дасгал хийх зэрэг буудахаас бусад үйлдэл үйлдэхийг зөвшөөрсөн тусгай зориулалтын цэгийг хэлнэ.

Аюулгүйн бүсэд сум болон түүнтэй ижил төстэй эд хэрэгсэл мөн сум бүхий магазиныг ил гаргах, гарт барих, буунд сумтай магазин угсрахыг хориглоно!

ЗУРГАА. ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ЖУРАМ

- Тэмцээнд оролцогч нь зарлагдсан хугацаанд багтан дасгал үйлдэх талбай дээр бүртгүүлнэ. Нөхөж дасгал гүйцэтгэх боломж буудагчид олгогдохгүй.
- Буудагч бүр дасгалыг гүйцэтгэсэн хугацааг хянаж гарын үсэг зурна.
- Дасгал гүйцэтгэх буудагч нь зөвхөн талбайн шүүгчийн командаар бууг гаргаж цэнэглэнэ. Дасгалыг гүйцэтгэх буудагч нь галын шугам дээр талбайн шүүгчийн "бууг цэнэглэж бэлдэнэ үү" командаар бууг гэр савнаас гарган цэнэглээд дасгалын заагдсан нөхцөлөөр бэлэн байдалд орно. Дараагийн "бэлэн үү" командын хариуд буудагч "Бэлэн" гэж хэлэх эсвэл толгой дохих, чимээгүй байдлаар дасгалыг гүйцэтгэхэд бэлэн гэдгийг илтгэнэ.
- Шүүгч "АНХААР" команд өгч 1-4 секундийн дараа дуут дохио дугарснаар дасгалыг эхлэх хугацаа явж, сүүлчийн буудалтаар хугацаа зогсоно.
- Дасгал гүйцэтгэсний дараа шүүгчийн "Хэрэв буудаж дууссан бол бууг шалгаж аюулгүй болгоод харуулна уу" гэх командаар цэнэггүй болгосон бууг шүүгчид харуулан дараагийн "Хяналтын буудлага, БУУ ГЭРТ" командаар буудагч аюулгүй байдлыг сахин аюулгүй болгосон бууг гэр саванд хийнэ.

ДОЛОО. ТЭМЦЭЭНЭЭС ДАРААХ ЗӨРЧЛӨӨР ХАСАГДАНА

- Дасгалыг гүйцэтгэх явцад буудлагын аюулгүйн өнцөг эвдсэн
- Дасгалыг гүйцэтгэх шилжилт хөдөлгөөний үед гох дээр хуруу тавьсан
- Дасгал гүйцэтгэх үед зүй бус үг хэллэг хэрэглэсэн буюу спортын бус байдлаар биеэ авч явсан
- Галын шугамаас гадна буунд магазин угсарсан, галын шугам, аюулгүйн бүсээс бусад газар шүүгчийн зөвшөөрөлгүй буутай харьцах үйлдэл хийсэн, Аюулгүйн бүсэд сум ил гаргаж, буунд сумтай магазин угсарсан.

Батлав:

**Монголын Гурван бууны
болон Төмөр буудлагын
холбоо**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П.ЭРДЭНЭБИЛЭГ